



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өмнөговь аймаг дахь Радио телевизийн сүлжээний газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ӨМА-2022/138-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.umnugovi@audit.gov.mn
Даланзадгад сум
2022 он

ТАГ-ын дарга, тэргүүлэх аудитор: С.Цэрэнбаяр
Утас: 70533539 Цахим хаяг: tserenbayars@audit.gov.mn
Аудитын менежер: Т.Хонгорзул
Утас: 70533552 Цахим хаяг: khongorzult@audit.gov.mn
Ахлах аудитор: Ж.Болормаа
Утас: 70533539 Цахим хаяг: Bolormaaaja@audit.gov.mn
Аудитыг гүйцэтгэсэн: “Эн Ай Ти Эс баланс Аудит” ХХК
Утас: 77270808 Цахим хаяг: nitsbalance@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу. **Нэг.**

Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

		/сая төгрөгөөр/	
	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	219.5	221.9
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	719.5	715.8
	Нийт хөрөнгийн дүн	939.0	937.7
	Нийт өр төлбөрийн дүн	0.0	0.0
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	939.0	937.7
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	939.0	937.7
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	276.2	297.9
	Үйл ажиллагааны зардлын дүн	254.3	299.2
	Үйл ажиллагааны үр дүн	21.9	1.3
	Үйл ажиллагааны бус үр дүн		
	Үйл ажиллагааны нийт үр дүн		
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	785.4	785.3
	Тайлант оны үр дүн	153.6	152.4
	Эцсийн үлдэгдэл	939.0	937.7
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	233.1	288.5
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	230.7	273.0
	Үйл ажиллагааны ЦМГ	2.4	15.5
	Хөрөнгө оруулалтын ЦМГ		17.7
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ		
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		2.4
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		0.2
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн		290.7
	Урсгал зардал		273.0
	Хөрөнгийн зардал		17.7
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр		288.5
	Улсын төсвөөс санхүүжих		284.1
	Орон нутгийн төсвөөс		4.4

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын зорилго нь харилцаа холбоо, Мэдээлэлийн технологийн шинэ дэвшилтэт технологийг ашиглан хэрэглэгчийн өнөөгийн болон ирээдүйн хэрэгцээг нь хангасан нийлмэл, орон зайнаас үл хамаарсан Радио телевизийн өргөн нэвтрүүлгийн үндэсний тоон технологийн сүлжээг өргөжүүлэн хөгжүүлэхэд оршжээ.

Дээрхи зорилгыг хэрэгжүүлэхийн тулд дараах үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлжээ.

- ✚ Өмнөд бүсийн аймаг, сумдын төвүүдэд радио, телевизийн бүсийн аймаг сумын төвүүдэд радио телевизийн өргөн нэвтрүүлгийн аналоги болон тоон технологийг өндөр түвшинд гологдол сааталгүй дамжуулах, радио телевизийн станцуудын тогтвортой тасралтгүй ажиллагааг хангах, гарсан гэмтлийг шуурхай илрүүлж засварлах;
- ✚ Өмнөд бүсийн радио телевизийн сүлжээний тогтвортой, найдвартай ажиллуулахад чиглэсэн үйл ажиллагаа явуулж, Өмнөговь, Дундговь аймаг дахь инженер техникийн ажилтнуудыг шуурхай удирдлагаар хангах.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ✚ Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр тушаалаар баталсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”;
- ✚ МУЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”;
- ✚ МУЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- ✚ Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”;
- ✚ Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д: “Нягтлан бодогч нь мэргэжлийн үйл ажиллагаандаа Монгол Улсын хууль тогтоомжийг мөрдөж ажиллана”; /2020 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн/
- ✚ МУЗГ-ын 2020 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 211 дүгээр тогтоолоор баталсан “Ковид 19” цар тахлын үед айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх зарим арга хэмжээний тухай”;
- ✚ МУЗГ-ын 2020 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 267 дугаар тушаалаар баталсан “Цахилгаан, дулааны уурын хангамж, хэрэглээг зохицуулах тухай”.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэлийн үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

МУЗГ-ын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам” гэж заасны дагуу дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам боловсруулаагүй, дотооддоо хяналт шалгалтын баг зохион байгуулаагүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторроос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Өмнөговь аймаг дахь Радио телевизийн сүлжээний газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Дэлхийн нийтээр ковид-19 цар тахалтай холбоотойгоор байгууллагын үйл ажиллагааны урсгал зардал хумигдсан байна.

Дөрөв. Аудитын гол асуудал

Өмнөговь аймаг дахь Радио телевизийн сүлжээний газрын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 13 арга хэмжээг төлөвлөснөөс, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт 98.0 хувийн хэрэгжилттэй тайлагнасан байна.

Төсөв захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 31,130.1 мянган төгрөгөөр өсгөсөн нь дээд шатны төсөв захирагч тоног төхөөрөмж худалдан авахад 17,700.0 мянган төгрөг, тэтгэвэрт гарах нэг удаагийн мөнгөн тэтгэмж зардалд 13,430.1 мянган төгрөгийг тус тус нэмэгдүүлж баталсантай холбоотой байна.

Төсөв санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас батлагдсан төсвийг тухайн байгууллагад албан бичиг, шийдвэр хавсарган ирүүлдэггүй, төсвийн төсөлтэй холбоотой тайлбар тодруулга авахгүйгээр төсвийг үндэслэлгүй хассан, төсвийн тодотголыг хууль тогтоомжид нийцүүлээгүй, төсвийг бүлэг хооронд шилжүүлэн зориулалт бусаар зарцуулах зэрэгт тавих хяналт сул байгааг цаашид анхаарах шаардлагатай.

Тав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Зургаа. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тайлант онд улс орныг хамарсан Ковид-19 цар тахлын улмаас аудитыг цахимаар хийж байгаагаас шалтгаалан байгууллага дээр ажиллаж нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэх, хөрөнгийн биет тооллого хийх гэх мэт хөрөнгийн хяналтыг бүрэн хэрэгжүүлэх нөхцөл байдал хязгаарлагдмал байсныг дараагийн тайлант хугацаанд анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

Долоо. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 4,766.6 мянган төгрөгийн 5 алдаа зөрчил илэрснээс 2,561.6 мянган төгрөгийн 1 зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 2,205.0 мянган төгрөгийн 1 зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 3 алдаа зөрчилд 4 зөвлөмж өгсөн ба залруулагдаагүй 6,398.4 мянган төгрөгийн алдаа зөрчил, тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшинээс 4,234.4 мянган төгрөгөөр их хэдий ч санхүүгийн тайланд нөлөөлгүй тул “Зөрчилгүй” дүгнэлт өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай залруулга завсрын аудитаар бүрэн хийгдсэн.

Төлбөрийн акт

Мөнгөн хөрөнгө дансны эхний үлдэгдэл 2,383.4 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 178.3 төгрөг, нийт 2,561.7 төгрөгийн зарцуулагдаагүй үлдэгдлийг улсын төсөвт буцаан шилжүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7-д: "энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсөв захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ" гэж заасантай нийцэхгүй, эрх үүрэг, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Улсын төсөвт буцаан төвлөрүүлэх 2,561.7 мянган төгрөгийг Өмнөговь аймгийн Төрийн сан банкин дахь (Хүү торгуулийн орлого) 100110000988 тоот дансанд шилжүүлэх

Албан шаардлага

2021 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангаар батлагдсан төсөвт зардлыг 2,205.0 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д: "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", мөн хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д: "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасантай тус тус нийцэхгүй, эрх үүрэг, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, мөн хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дэх заалтуудыг тус тус хэрэгжүүлэн зөрчлийг давтан гаргахгүй байж, хууль тогтоомжийг мөрдөж ажиллах

Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

2021 оны төсвийн гүйцэтгэлийн тайланг төсвийн тухай хуулийн холбогдох заалтын дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлээгүй байна.

1.2. Эрсдэл:

Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4 дэх заалтыг хэрэгжүүлээгүй байна.

1.3. Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4-д: “Төсвийн гүйцэтгэлийн тайлан нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна” гэж заасныг мөрдөж ажиллах

2. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Тайлант хугацаанд шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 153 мэдээллээс 128 мэдээллийг хугацаанд нь оруулж, 25 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

2.2. Эрсдэл:

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2 дахь заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.

2.3. Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх” гэж заасныг мөрдөж ажиллах

3. Дотоод хяналттай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

МУЗГ-ын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам” гэж заасны дагуу 2020-2021 оны хичээлийн жилд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам боловсруулаагүй, хяналт шалгалтын баг зохион байгуулаагүй байна.

3.2. Эрсдэл:

МУЗГ-ын 2011 оны 311 дүгээр тогтоолын заалтыг хэрэгжүүлээгүй байна.

3.3. Өгсөн зөвлөмж:

МУЗГ-ын 2011 оны 311 дүгээр тогтоолын дагуу дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулах журам боловсруулж, дотооддоо хяналт шалгалтын баг ажиллуулах

7.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			

2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
НИЙТ		1	1			1			

7.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	ТШЗ	5	4.7			1	2.5	1	2.2	3	0.0
2	Төсөл, хөтөлбөр										
3	ЗГТС										
4	ТТЗ										
5	ТЕЗ										
НИЙТ		5	4.7			1	2.5	1	2.2	3	0.0